| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | 00,00                           | 00,00                 | 00,00                  | 00,00                                   |
| D08 | Тайлант үеийн үр дүн                             | 00,00                           | 00,00                 | -44 592 249,82         | -44 592 249,82                          |
| D09 | <b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>1 154 614 547,09</b>         | <b>63 648 522,31</b>  | <b>-304 598 363,87</b> | <b>913 664 705,53</b>                   |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт                                                  | Тайлант оны           |                  |
|-----------------------|-----------------------------------------------------------|-----------------------|------------------|
|                       |                                                           | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл        |
| <b>1</b>              | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>   |                       |                  |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                  | 1 138 408 300,00      | 1 046 735 680,62 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                      | 1 138 408 300,00      | 1 046 735 680,62 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                    | 1 077 426 500,00      | 985 833 280,62   |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                  | 815 549 100,00        | 757 528 449,49   |
| 210101                | Үндсэн цалин                                              | 541 092 400,00        | 450 255 587,69   |
| 210102                | Нэмэгдэл                                                  | 196 249 100,00        | 233 961 589,61   |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 30 294 000,00         | 26 592 500,00    |
| 210104                | Урамшуулал                                                | 47 913 600,00         | 46 718 772,19    |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>     | 101 943 700,00        | 93 870 874,52    |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                        | 72 880 300,00         | 66 839 953,13    |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                        | 7 265 800,00          | 7 204 332,56     |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                         | 5 812 700,00          | 5 542 446,36     |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                      | 1 453 200,00          | 1 295 725,64     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                     | 14 531 700,00         | 12 988 416,83    |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                   | 21 058 500,00         | 15 624 123,00    |
| 210401                | Бичиг хэрэг                                               | 2 043 000,00          | 2 009 690,00     |
| 210402                | Тээвэр, шатахуун                                          | 2 978 600,00          | 2 403 000,00     |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 4 257 800,00          | 4 039 886,00     |
| 210404                | Ном, хэвлэл                                               | 1 876 400,00          | 1 015 677,00     |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4 701 700,00          | 1 022 600,00     |

|             |                                                                                       |                  |                  |
|-------------|---------------------------------------------------------------------------------------|------------------|------------------|
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                           | 5 201 000,00     | 5 133 270,00     |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                                               | 67 657 100,00    | 50 027 001,00    |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                                       | 1 167 600,00     | 1 166 832,00     |
| 210502      | Хоол, хүнс                                                                            | 64 770 000,00    | 47 152 169,00    |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                                           | 1 719 500,00     | 1 708 000,00     |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                              | 14 064 700,00    | 14 048 700,00    |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                                               | 741 100,00       | 740 000,00       |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                                          | 4 892 000,00     | 6 109 100,00     |
| 210604      | Урсгал засвар                                                                         | 8 431 600,00     | 7 199 600,00     |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                                         | 4 754 100,00     | 3 063 400,00     |
| 210702      | Дотоод албан томилолт                                                                 | 4 754 100,00     | 3 063 400,00     |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                       | 3 865 000,00     | 3 147 480,00     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                  | 1 016 900,00     | 1 016 900,00     |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                              | 1 485 000,00     | 1 008 000,00     |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                                            | 178 200,00       | 148 580,00       |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                                         | 36 000,00        | 33 000,00        |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                                       | 950 900,00       | 941 000,00       |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                                | 48534300,00      | 48523252,61      |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                                     | 48 534 300,00    | 48 523 252,61    |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                               | 60981800,00      | 60902400,00      |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                         | 60 981 800,00    | 60 902 400,00    |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                   | 35 436 400,00    | 35 436 400,00    |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 24 645 000,00    | 24 645 000,00    |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                               | 900 400,00       | 821 000,00       |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                 | 1 138 408 300,00 | 1 046 735 680,62 |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                                        | 1 138 408 300,00 | 1 046 735 680,62 |
| 131001      | Улсын төсвөөс санхүүжих                                                               | 1 138 408 300,00 | 1 046 735 680,62 |
| 132007      | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                                               |                  |                  |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                                               | 51,00            | 51,00            |
| 620001      | Удирдах ажилтан                                                                       | 03,00            | 03,00            |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                                                                     | 30,00            | 30,00            |
| 620003      | Үйлчлэх ажилтан                                                                       | 18,00            | 18,00            |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт                                                             | Өмнөх он | Гүйцэтгэл            |
|-------------|----------------------------------------------------------------------|----------|----------------------|
|             | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              |          |                      |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             |          | <b>14 083 600,00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                 |          | <b>14 083 600,00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               |          | 14 083 600,00        |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             |          | 5 700 000,00         |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                              |          | 4 200 000,00         |
| 210604      | Урсгал засвар                                                        |          | 1 500 000,00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      |          | 1 314 104,00         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж |          | 1 314 104,00         |

|        |                                                                              |      |               |
|--------|------------------------------------------------------------------------------|------|---------------|
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                              | 0,00 | 7069496,00    |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                            |      | 7 069 496,00  |
| II     | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                        | 0,00 | 14083600,00   |
| 1311   | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                           |      | 14 083 600,00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого |      | 14 083 600,00 |
| IV     | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                              |      |               |
|        | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                             |      |               |
|        | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                            |      |               |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь сургуулийн хөгжлийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг нь иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах үйл ажиллагаа юм.

Байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 145,778.3 мянган төгрөгөөр буюу 15.9%-аар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       | Өөрчлөлт              | Хувь         |
|----------------------------------------------|-----------------------|-----------------------|-----------------------|--------------|
| Б                                            | 1                     | 2                     | 3=2-1                 |              |
| Мөнгөн хөрөнгө                               | -                     | -                     | -                     |              |
| Авлага                                       | -                     | -                     | -                     |              |
| Бараа материал                               | 60,304,788.09         | 73,224,464.89         | 12 919 676,80         | 17,6%        |
| Үндсэн хөрөнгө                               | 707,965,203.87        | 840,915,840.64        | 132 950 636,77        | 15,8%        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>768,361,955.35</b> | <b>914,140,305.53</b> | <b>145 778 350,18</b> | <b>15,9%</b> |
| Өр төлбөр                                    | -                     | 475,600.00            | 475 600,00            | 100,0%       |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 768,361,955.35        | 913,664,705.53        | 145 302 750,18        | 15,9%        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>768,361,955,35</b> | <b>914,140,305.53</b> | <b>145 778 350,18</b> | <b>15,9%</b> |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 840,915.8 мянган төгрөг болж, 132,950.6 мянган төгрөгөөр буюу 15.8%-иар өссөн нь шинээр баригдах сургуулийн 37,979 метр квадрат газрыг 189,895.0 мянган төгрөгөөр биет бус хөрөнгөөр бүртгэн авсанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 291,297.1 мянган төгрөг буюу 20.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт 281,568.2 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

#### Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                  | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         | Өөрчлөлт              | Хувь         |
|-------------------------------------------|-------------------------|-------------------------|-----------------------|--------------|
| Б                                         | 1                       | 2                       | 3=2-1                 | 4=3/2        |
| Үйл ажиллагааны орлогын дун               | <b>1 160 992 274,00</b> | <b>1 452 266 384,84</b> | <b>291 274 110,84</b> | <b>20,1%</b> |
| Тусламж, санхүүжилтийн орлого             | 1 156 244 400,00        | 1 434 695 591,84        | 278 451 191,84        | 19,4%        |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих            | 00,00                   | 281 568 191,84          | 281 568 191,84        | 100,0%       |
| <b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>        | <b>1 234 931 059,81</b> | <b>1 496 858 634,66</b> | <b>261 927 574,85</b> | <b>17,5%</b> |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 189 487 578,00          | 226 480 510,00          | 36 992 932,00         | 16,3%        |
| Гэрэл, цахилгаан                          | 5 789 398,00            | 8 537 182,89            | 2 747 784,89          | 32,2%        |
| Түлш, халаалт                             | 169 626 640,00          | 195 392 607,26          | 25 765 967,26         | 13,2%        |
| Цэвэр, бохир ус                           | 14 071 540,00           | 22 550 719,85           | 8 479 179,85          | 37,6%        |
| Хоол, хүнс                                | 26 273 109,64           | 45 768 751,79           | 19 495 642,15         | 42,6%        |

|                                                     |               |               |               |       |
|-----------------------------------------------------|---------------|---------------|---------------|-------|
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                   | 28 207 763,10 | 57 229 358,41 | 29 021 595,31 | 50,7% |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11 837 900,00 | 35 436 400,00 | 23 598 500,00 | 66,6% |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг         | 7 723 888,52  | 92 365 749,38 | 84 641 860,86 | 91,6% |

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 261,927.6 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс Байрны ашиглалтын зардал буюу цахилгаан, халаалт, цэвэр бохир усны зардал 36,992.9 мянган төгрөг буюу 16.3 хувиар, Хоол хүнсний зардал 19,495.6 мянган төгрөг буюу 42.6 хувиар, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 29,021.6 мянган төгрөг буюу 50.7 хувиар, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 23,598.5 мянган төгрөг буюу 66.6 хувиар тус тус өссөн нь материаллаг хэмжээний өөрчлөлтүүд байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,138,408.3 мянган төгрөг, үйл ажиллагааны нэмэлт орлогоос 14,719.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжих орлого 281,568.2 мянган төгрөг, нийт зарлагыг 1,234,931.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 50.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 зорилго, 9 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,434,060.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,342,379.99 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 93.6 хувьтай хэрэгжсэн байна

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| д/д | Зардал                                                | Төлөвлөгөө          | Гүйцэтгэл           | Хэмнэлт          | Хувь         |
|-----|-------------------------------------------------------|---------------------|---------------------|------------------|--------------|
| 1   | 71804 80101-үндсэн үйл ажиллагааны зардал             | 1 026 740,10        | 952 764,70          | 73 975,40        | 87,1%        |
| 2   | 71804 80802-ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал   | 60 981,80           | 60 902,40           | 79,40            | 99,9%        |
| 3   | 71804 81806-дотуур байрны үйлчилгээ                   | 64 770,00           | 47 152,20           | 17 617,80        | 72,8%        |
| 4   | 71804 80111-байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 226 488,10          | 226 480,50          | 7,60             | 100,0%       |
| 5   | 71804 80112 үндсэн үйл ажиллагааны зардал             | 55 080,20           | 55 080,10           | 0,10             | 100,0%       |
|     | <b>Нийт дүн</b>                                       | <b>1 434 060,20</b> | <b>1 342 379,90</b> | <b>91 680,30</b> | <b>93,6%</b> |

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,719.1 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилт 281,568.2 мянган төгрөгийн орлогыг санхүүжүүлсэн байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд 5 хөтөлбөр, 9 зорилгын хүрээнд нийт 55 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 96.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг хавсаргав

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах М.Уламбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 18,524.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,966.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 261,927.6 мянган төгрөг буюу 17.5%-иар нэмэгдсэн байна. Тухайлбал: Цахилгааны зардал 2,747.8 мянган төгрөг буюу 32.2%, Түлш халаалтын зардал 25,766.0 мянган төгрөг буюу 13.2%, Цэвэр бохир ус 8,476.2 мянган төгрөг буюу 37.6%-иар өссөн байна.

Өнгөрсөн оноос өссөн шалтгаан нь халаалтын зардлыг 7 сараар тооцдог байсныг 8 сараар, тухайлбал халаалтыг хавар 5-р сарын 15 хүртэл, намар 9-р сарын 15-наас эхэлж өгч эхэлсэн, дотуур байрны халаалтыг айл өрхөөр тооцдог үнэ нэмэгдсэн, дулааны суурь хураамж нэмэгдсэн, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны хэрэглээ өмнөх оноос нэмэгдсэн.

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 2,848.7 мянган төгрөг буюу 76.3%, Хоол хүнс 19,495.6 мянган төгрөг буюу 42.6%, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 29,021.6 мянган төгрөг буюу 50.7% -иар тус тус нэмэгдсэн байна.

2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж зардал бага гарч байсан бол тайланд онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1.-д “...тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой.” Гэж заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас Шилэн дансны оруулбал зохих 145 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь оруулсан 4 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Оруулаагүй мэдээлэл байхгүй.

Цалин, НДШ болон Дөрвөлж ХХК-д шилжүүлсэн халаалтын зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш төгрөгийн зарцуулалт байхгүй байна.

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 18,333.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,929.4 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд акт тогтоож, 16,404.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгө, шилэн данстай холбоотой зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |                 |             |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|-------------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн             | Хувь        |
| Акт             | 1                      | 1,929.4         | 1        | 1,929.4         | 100%        |
| Албан шаардлага | 1                      | 16,404.1        | 1        | 16,404.1        | 100%        |
| Зөвлөмж         | 2                      | -               | 2        | -               | -           |
| <b>Нийт дүн</b> | <b>4</b>               | <b>18,333.5</b> | <b>4</b> | <b>18,333.5</b> | <b>100%</b> |

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

##### 5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: МСҮТ нь нийт 74 аж ахуйн нэгж байгууллага болон иргэдтэй холбоотой 54,199.1 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д “Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, мөн “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг бүрэн хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

### **1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан цаг хугацаанд тогтмол мэдээлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| /мянган төгрөгөөр/                                                 |            |          |                                   |          |                          |     |            |     |              |          |         |          |
|--------------------------------------------------------------------|------------|----------|-----------------------------------|----------|--------------------------|-----|------------|-----|--------------|----------|---------|----------|
| Алдааны товч утга                                                  | Нийт алдаа |          | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |          | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |     |              |          | Зөвлөмж |          |
|                                                                    |            |          |                                   |          |                          |     | Залруулсан |     | Залруулаагүй |          |         |          |
|                                                                    | Тоо        | Дүн      | Тоо                               | Дүн      | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн | Тоо          | Дүн      | Тоо     | Дүн      |
| татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй зардал | 1          | 54,199.1 | 1                                 | 54,199.1 | -                        | -   | -          | -   | 1            | 54,199.1 | 3       | 54,199.1 |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга                                       |     | Нийт зөрчил |     | /мянган төгрөгөөр/ |     |                 |     |         |  |
|----------------------------------------------------------|-----|-------------|-----|--------------------|-----|-----------------|-----|---------|--|
|                                                          |     |             |     | Үүнээс             |     |                 |     |         |  |
|                                                          |     |             |     | Төлбөрийн акт      |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |  |
| Тоо                                                      | Дүн | Тоо         | Дүн | Тоо                | Дүн | Тоо             | Дүн |         |  |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |     |             |     |                    |     |                 |     |         |  |
| Шилэн дансны тухай хуулийн хугацаа хоцорч мэдээлсэн      | 3   | -           | -   | -                  | -   | -               | 3   | -       |  |
| Дүн                                                      | 3   | -           | -   | -                  | -   | -               | 3   | -       |  |